

МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 07 өдөр

№ А/14

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн дүрмийн 10.6.12, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн “Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Журмыг нийт ажилчдад мөрдүүлж ажиллахыг Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын хэлтэс (Ч.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Л.Нямчулуун)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ





ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧИХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (цаашид “Компани” гэх)-ийн ажилтан, гэрээт ажилтан, дадлагын оюутан, зочид төлөөлөгчид (цаашид “Зорчигч” гэх) компанийн тээврийн хэрэгслээр хөдөө, орон нутаг, үйлдвэр орчмын хатуу хучилттай автозам болон шороон замаар зорчиход аюулгүй ажиллагааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь үйлдвэрт ажиллаж байгаа тусгай зориулалтын машин механизмаас бусад бүх төрлийн компанийн тээврийн хэрэгсэл (турээсийн тээврийн хэрэгсэл)-ийг жолоодож буй тээврийн хэрэгслийн жолооч болон зорчигчид хамаарна.

1.3. Жолооч, зорчигчид нь компанийн төв байр, үйлдвэр болон орон нутагт зорчих, буцаж ирэхдээ Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Үйлдвэр болон орон нутагт зорчих, ирэх бэлтгэл хангах

2.1. Жолооч болон зорчигчид нь үйлдвэр болон орон нутагт зорчих, буцаж ирэх бэлтгэлийг дараах байдлаар хангана. Үүнд:

- 2.1.1. Жолооч болон зорчигчид нь энэхүү журамтай урьдчилан танилцаж холбогдох зааварчилгааг аван, цаг агаарын нөхцөлд тохируулан хувийн бэлтгэлээ хангасан байх;
- 2.2.2. Жолооч болон зорчигчид нь компанийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан нэгжийн эрх бүхий ажилтан (цаашид “зааварлагч” гэх)-аас аяллын талаарх тусгай зааварчилгаа авсны үндсэн дээр энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан “Аяллын ХАБЭА-н зааварчилгаа өгөх хуудас”-ыг бүрэн гүйцэд бөглөж, гарын үсэг зурсан байх;
- 2.2.3. Тээврийн хэрэгслийн жолооч нь үйлдвэр болон орон нутагт зорчихын өмнө тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан “Тээврийн хэрэгслийг шалгах хуудас”-ын дагуу заавал биечлэн шалгаж, хуудсыг бүрэн гүйцэд бөглөсөн байна. Тээврийн хэрэгсэл бүрэн бүтэн бус эвдрэл гэмтэлтэй эсхүл багаж хэрэгсэл дутуу тохиолдолд засуулах арга хэмжээ авсны дараа буюу нөхөж бүрдүүлсний дараа замд гарна.
- 2.2.4. Тээврийн хэрэгслийн жолооч нь улирал, цаг агаар, замын нөхцөл, маршрутын дагуух дэд бүтцийн байдлаас шалтгаалан тээврийн хэрэгсэл, зорчигчдын аюулгүй байдлыг хангах иж бүрдэл болон нэмэлт хэрэгслүүд /Сансрын холбооны утас буюу IRIDIUM, GPS, майхан, гол түлэх болон хоол хийх хэрэгсэл, гар чийдэн, кенгуру жэк, хүрз, нөөц дугуй г.м/ байгаа эсэхийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан “Аялалд бэлтгэх хуудас”-ын дагуу шалгана.
- 2.2.5. Ямар ч тохиолдолд 5л-ээс багагүй хэмжээний цэвэр усны нөөцтэй явах бөгөөд

зуны улиралд тээврийн хэрэгсэл тус бүрд 1-2 хайрцаг цэвэр ус, өвлийн улиралд цэвэр уснаас гадна илчлэг сайтай хоол хүнс авч явна.

2.2. Энэхүү журмын 2.1.2 - 2.1.4 дүгээр зүйлүүдэд заасан хуудаснуудыг бүрэн гүйцэд бөглөж хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнаар баталгаажуулан захиргаа хариуцсан нэгжийн ажилтанд хэвлэмэл байдлаар заавал өгсөн байна. Хуудсыг бөглөөгүй, дутуу бөглөсөн, гарын үсэг зураагүй, баталгаажуулаагүй тохиолдолд үйлдвэр болон орон нутагт зорчихыг хориглоно.

Гурав. Жолоочид тавигдах ерөнхий шаардлага,
авах арга хэмжээ

3.1. Тээврийн хэрэгслийг жолоодох жолооч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөх ба дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.1.1. Урт хугацаагаар буюу 8 цагаас дээш хугацаагаар замд явах жолооч нь хангалттай буюу хамгийн багадаа 6-8 цаг унтаж амарсан байх шаардлагатай;
- 3.1.2. 10 цаг ба түүнээс дээш хугацаагаар ганцаараа тээврийн хэрэгсэл жолоодох тохиолдолд амралтын зогсолт болон шөнийн зогсолт хийх төлөвлөгөөтэй байх;
- 3.1.3. 2 цаг тутам заавал 10 минут амрах ёстой бөгөөд ямар ч тохиолдолд 10 цагаас дээш хугацаагаар жолоо барихгүй байх;
- 3.1.4. Тээврийн хэрэгслийн суудлын бүсний тоогоор зорчигч тээвэрлэх, замд гарахын өмнө зорчигчдын суудлын бүсийг бүслүүлэх;
- 3.1.5. Тээврийн хэрэгслийн ангиллын дагуу жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх, холбогдох сургалт, дамжаанд хамрагдсан байх;
- 3.1.6. Тээврийн хэрэгслийн үзлэгийг замд гарахын өмнө болон долоо хоног тутамд хийх;
- 3.1.7. Тээврийн хэрэгслээр явсан км, хийсэн үйлчилгээний талаарх бүртгэлийг тухай бүр хөтлөх;
- 3.1.8. Тээврийн хэрэгслийн гэмтэл, засварын талаарх мэдээллийг тухай бүрд нь Захиргаа хариуцсан нэгжийн тээврийн хэрэгсэл хариуцсан ажилтанд мэдээлж, тойрох үзлэгийн хуудсан дээр тэмдэглэх байх;
- 3.1.9. Зохих зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэлд засвар, үйлдвэрийн хийцэд өөрчлөлт оруулахгүй байх;
- 3.1.10. Зорчигчдыг ая тухтай зорчуулах, халтирч унах аюулаас сэргийлэх нөхцлийг бүрдүүлж, тээврийн хэрэгслийг байнга цэвэрхэн байлгах;
- 3.1.11. Үйлдвэр болон орон нутагт зорчих, буцаж ирсний дараа эсхүл тээврийн хэрэгслийг бусад жолоочид шилжүүлэх тохиолдолд энэхүү журмын гуравдугаар хавсралт болох “Тээврийн хэрэгслийг шалгах хуудас”-ыг бөглөн Захиргаа хариуцсан нэгжийн тээврийн хэрэгсэл хариуцсан ажилтан болон бусад жолоочид хүлээлгэн өгөх;
- 3.1.12. Өөрийн шууд удирдлага болон жолооч, зорчигч нарыг удирдаж явах ажилтны зөвшөөрөлгүйгээр гадны зорчигч тээвэрлэхгүй байх, онцгой шаардлагаар гадны зорчигч зорчих тохиолдолд энэ талаар өөрийн шууд удирдлагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах;

3.2. Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс жолооч нь дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- 3.2.1. Компанийн төв байр, үйлдвэр болон орон нутагт тээврийн хэрэгслээр зорчих, буцаж ирэх замд яваа хугацаанд жолооч аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тавьж ажиллана.
- 3.2.2. Дөрвөн цаг тутам үүрэн холбооны сүлжээтэй газраас, сүлжээгүй тохиолдолд сансрын утсаар хүний нөөц, захиргаа хариуцсан нэгжийн ажилтан эсхүл хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан нэгжийн ажилтантай холбогдон дараах мэдээллийг өгнө. Үүнд:
- Тээврийн хэрэгслийн байршил, цаг агаарын нөхцөл байдал,
 - Тухайн өдрийн аяллын төлөвлөгөө, замын маршрутын хувилбар,
 - Тулгарч буй аливаа эрсдэл, саад байгаа эсэх,
 - Дараагийн холбоо барих цэг,
 - Тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдын тоо, биеийн байдал
- 3.2.3 Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг орон нутгийн автозамд 80 км/ц, хот, суурингийн автозамд 60 км/ц, сумын төвд 50 км/ц, төслийн талбай дээр 40 км/цагаас хэтрүүлэлгүй зорчих ба цаг агаар, үзэгдэх орчин, автозамын нөхцөлдөө тохируулан хурдыг тохируулах, үзэгдэх орчин хязгаарлагдмал байх нөхцөлд тээврийн хэрэгслийг зогсоож цааш явах замыг тодруулсны дараа хөдөлгөөнийг үргэлжлүүлэх; /энэхүү журмаар тогтоосон хурдны хязгаар автозамын тэмдгийн заалттай зөрчилдсөн тохиолдолд автозамын тэмдгийн заалтыг баримтлах/
- 3.2.4 Аяллын туршид согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхгүй байх;
- 3.2.5 Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр асаалттай байх үед түлш цэнэглэхгүй байх;
- 3.2.6 Гар утсыг зөвхөн тээврийн хэрэгсэл зогсож буй үед болон аюулгүй байрлалд байгаа үед л хэрэглэх;
- 3.2.7. Өмнөх замын үзэгдэх орчин тодорхой бус үед өөр тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхгүй байх, өмнө зорчиж буй тээврийн хэрэгсэл чиглэл, хурдаа тогтмол барьж явах эрсдэлгүй үед гүйцэж түрүүлэх үйлдлийг хийх;
- 3.2.8. Автозам нарийссан эсвэл гүүр болон гарцын өөр сонголтгүй, автозам дээрх тээврийн хэрэгсэл автозамаас хазайн саад жалга ховилоос зайлсхийх боломжгүй тохиолдолд гүйцэж түрүүлэхгүй байх;
- 3.2.9. Цаг агаарын хуурай нөхцөлд өмнө зорчиж буй тээврийн хэрэгслээс хамгийн багадаа 5 секундын зайд, чийгтэй нойтон нөхцөлд хамгийн багадаа 8 секундын зайд тус тус баримтлан явах;
- 3.2.10. Компанийн тээврийн хэрэгслээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр ямар ч тохиолдолд мөстсөн гол мөрөн, нууран дээгүүр зорчихгүй байх;
- 3.2.11. Осол, аваарын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд тээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх, тухайн орон нутгийн цагдаагийн байгууллага болон даатгалын компанийд дуудлага өгч, холбогдох ослын дүгнэлт, шийдвэрийг гаргуулах;
- 3.2.12. Тээврийн хэрэгслийг жолоодоход тохиромжгүй гутал, хувцас, малгай, нүдний шил өмсөхгүй байх.

3.3. Хүний нөөц, захиргаа хариуцсан нэгжийн ажилтан нь тээврийн хэрэгслээр зорчих зорчигчдын мэдээлэл, явах автозам, маршрут болон аяллын талаарх бусад мэдээллийг жолооч болон зорчигч нарыг удирдаж явах ажилтан, төв оффис болон хотхон, үйлдвэрийн оффисын холбогдох ажилтанд мэдэгдэх бөгөөд замд гарсан цаг болон хүрэх газар, очих хугацаа зэргийг тооцоолон тэмдэглэл үйлдэнэ.

3.4. Өвлийн улиралд 20.00 цаг, зуны улиралд 21.30 цагаас хойш алсын замд зорчихыг хориглоно.

3.5. Тээврийн хэрэгслийн жолооч болон зорчигчид нь дараах хамгаалах хэрэгслийг үйлдвэр болон орон нутагт зорчих, буцаж ирэх үед хэрэглэх бөгөөд жолооч нь хамгаалах хэрэгслийн хүрэлцээг тухай бүрд нь мэдээлж, шаардлагатай тохиолдолд захиалах арга хэмжээг авна. Үүнд:

- 3.5.1. Үзэгдэх орчин хязгаарлагдсан (харуй бүрий, цас, бороо, манан г.м) цаг агаарын нөхцөлд тохирсон нүдний шил зүүх;
- 3.5.2. Тээврийн хэрэгслийн эд анги шалгах, засвар үйлчилгээ хийх үед нүд хамгаалах шил зүүж, гар тулэгдэх, зүсэгдэхээс хамгаалж бээлий өмсөх;
- 3.5.3. Үйлдвэрийн бүсэд нэвтрэх үед нүд болон чих хамгаалах хэрэгсэл зүүх, гэрэлтдэг хантааз, хамгаалах дуулга малгай, ажлын гутал өмсөх.

Дөрөв. Зорчигчийн үүрэг

4.1. Зорчигч нь энэхүү журмын 2.1.2 дугаар зүйлд заасан “Аяллын ХАБЭА-н зааварчилгаа өгөх хуудас”-ыг бүрэн гүйцэд бөглөж гарын үсэг зурна.

4.2. Зорчигч нь аялалд зориулан хувийн бэлтгэлээ сайтар хангасан байна.

4.3. Осол, аваарын үед жолооч болон бусад зорчигчид туслах, холбогдох байгууллага болон компанид мэдэгдэх, тусlamж дуудах арга хэмжээ авна.

4.4. Зорчигч нь тээврийн хэрэгслээр зорчих үед аюулгүй байдлын үүднээс жолоочийн тавьсан аливаа шаардлагыг биелүүлэх үүрэгтэй ба дараах зүйлсийг аяллын турш хориглоно. Үүнд:

- 4.4.1. Жолоочын анхаарлыг сарниулах аливаа үйлдэл хийх
- 4.4.2. Согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх
- 4.4.3. Тээврийн хэрэгсэлд тамхи татах, ил гал гаргах

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд гаргасан зөрчлийн шинж чанар, гэм буруу, үр дагаварыг харгалzan компанийн Хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан Хөдөлмөрийн гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Үйлдвэр болон орон нутагт зорчих, буцаж ирэх үед жолооч болон зорчигчид суудлын бүс хэрэглээгүй болон хамгаалах хэрэгсэл хэрэглээгүйн улмаас бэртэж, гэмтсэн тохиолдолд компани ямар нэг хариуцлага, үүрэг хүлээхгүй болно.

5.3. Компанийн томилгоот тээврийн хэрэгслээс бусад аливаа тээврийн хэрэгслээр зорчсоны улмаас осолд өртөх, бусад өөрийн буруугаас шалтгаалан үүссэн аливаа асуудалд компани ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Аяллын ХАБЭА-н зааварчилгаа өгөх хуудас
/ health and safety instruction sheet/

Автомашины улсын дугаар:.....

Чиглэл:.....

Хугацаа:.....

№	Зааварчилгаа (Жолооч)	Танилцсан
1	Компанийн албан томилотын журмыг чанд мөрд	<input checked="" type="checkbox"/>
2	Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрд	
3	МҮ-ын замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрд	
4	Бүсээ байнга бүсэл, хэн нэгэн бүслээгүй байвал бүү хөдөл!	
5	Зааварчилгаа аваагүй бол юу ч битгий хий, бүү ажилд гар!	
6	Батлагдсан чиглэлээр зорчих, зайлшгүй өөрчлөх шаардлага гарвал удирдлах ажилтанд мэдэгдэх	
7	Машин техникийн бүрэн бүтэн байдлыг заавал шалга!	
8	Илүү зорчигч авч явахыг хатуу хориглоно!	
9	Аливаа асуудал гарвал удирдлагатайгаа заавал холбоо барь, мэдээлэл, заавар, зөвшөөрөл авах!	
10	Согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэхийг хатуу хориглоно!	
11	Ямар нэгэн осол аваар гэх мэт онцгой байдал үүсвэл 70100390, 99004222, 99182713 дугаарт мэдэгдэх!	

Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан жолооч:

_____ / _____ / _____
 Овог, нэр Гарын үсэг Он, сар, өдөр

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн ажилтан:

_____ / _____ / _____
 Овог, нэр Гарын үсэг Он, сар, өдөр

№	Зааварчилгаа/Instruction (Зорчигч / Passenger)	Танилцсан/ check if completed <input checked="" type="checkbox"/>
1	Компанийн албан томилолтын журмыг чанд мөрд / Company employees should comply with safety regulations during the appointment	
2	Бүсээ байнга бүсэл, машинд бус байхгүй бол бүү сүү! / Seatbelt must be worn at all times. Do not board if the vehicle is not equipped with seatbelts!	
3	Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрд / To comply with safety regulations when traveling by car	
4	Аливаа асуудал гарвал удирдлагатайгаа заавал холбоо барь, Мэдээлэл, заавар, зөвшөөрөл авах / If you have any problems, to contact your administer and to obtain information, instruction and permission	
5	Зорчих чиглэлээ өөрчлөх шаардлага гарвал удирдах ажилтанд мэдэгдэх / Inform the management if it is necessary to travel in a different direction than the approved route	
6	Ямар нэгэн осол аваар гэх мэт онцгой байдал үүсвэл 70100390, 99004222, 99182713 дугаарт мэдэгдэх / In case of emergency or accident, please call and inform 70100390, 99004222, 99182713	

Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан зорчигч/ Passenger :

/ /
Овог, нэр / Name Гарын үсэг/Signature Он, сар, өдөр / Date

Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан зорчигч/ Passenger :

/ /
Овог, нэр / Name Гарын үсэг/Signature Он, сар, өдөр / Date

Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан зорчигч/ Passenger :

/ /
Овог, нэр / Name Гарын үсэг/Signature Он, сар, өдөр / Date

Аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан зорчигч/ Passenger :

/ /
Овог, нэр / Name Гарын үсэг/Signature Он, сар, өдөр / Date

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн ажилтан/ Instructor :

/ /
Овог, нэр / Name Гарын үсэг/Signature Он, сар, өдөр / Date

Аялалд бэлтгэх хуудас

Автомашины улсын дугаар:.....

Чиглэл:.....

Хугацаа:.....

№	Аяллын өмнө <u>заавал</u> хийж гүйцэтгэх зүйлс	Дууссан эсэхийг шалгах /жолооч/	Шалгасан хүний нэр
1	Тээврийн хэрэгслийн үзлэг шалгалт		
2	Тоног төхөөрөмжийн үзлэг шалгалт		
3	Цэвэр усны нөөц эсвэл шаардлагатай хүнсний хангамжтай эсэх		
4	Аяллын маршруттай танилцсан эсэх		
5	Сансарын холбооны утас, GPS, бусад холбооны төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх		
6	Хүний нөөцийн бүртгэлд хамрагдсан эсэх		
7	Жолоочын болон тээврийн хэрэгслийн бичиг баримт бүрэн эсэх		
8	Томилолтын төсөв, бэлэн мөнгө		
9	Анхны тусламжийн хайрцаг, ослын тэмдэг, данхрат, дорцов, ивүүр, хүрз, татлага		

Тээврийн хэрэгслээр зорчих зөвшөөрөл олгосон: _____

Гарын үсэг: _____

Огноо: _____

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ШАЛГАХ ХУУДАС

№	Үзлэг хийх дараалал / Inspection Item	Normal Хэвийн	Not normal Хэвийн бус
1	Хөдөлгүүрийн тосны түвшин / Engine oil level		
2	Хөргөлтийн систем / Cooling system		
3	Тормозны ажиллагаа / Brake operation		
4	Шил арчигчууд / Windshield wiper blades		
5	Гэрэл дохионууд шалгах / Head lights/driving lights		
6	Жолооны системийн хоолойнууд / Power steering hoses		
7	Зогсоолын тормоз / Park brake operation		
8	Сэнсний ремен / Fan belt		
9	Суудлын даруулгууд / Seat belts		
10	Толинууд: Хажуугийн болон арын г.м / Mirrors: side rear-veiw		
11	Цасны гинжүүд (шаардлагатай бол) / Snow chains (if applicable)		
12	Хүч дамжуулах шингэнийг шалгах / Transmission fluid level		
13	Тормозны гэрлүүд/ эргэх дохионууд / Brake lights/turn lights		
14	Тормозны шингэний түвшинг шалгах / Brake fluid level		
15	Арын гэрлүүд ухрах дохионы гэрэл / Tail lights/reverse lights		
16	Жолооны шингэн (гидрийн шингэн) / Power steering fluid		
17	Дугуй: Хээний элэгдэл болон хийн даралтыг шалгах / Tire: wear/correct pressure		
18	Нөөц дугуй / Spare tire condition		
19	Дуут дохио / Horn		
20	Хөргөлтийн шингэний түвшинг шалгах / Anti-freeze level		
21	Халаагуур болон агааржуулалтын ажиллагаа / Heater and AC function/		
22	Улсын техникийн үзлэгийн хуудас ба техникийн гэрчилгээ бүрэн эсэхийг шалгах / Quarterly inspection sticker certificate/		
23	Ивүүр / Wheel chock		
24	Цэвэрлэгээ / Cleanliness of vehicle		
25	Ачааны даруулга тохирсон эсэхийг шалгах / Suitable and sufficient and cargo tie-downs		
26	Ачаа зөв найдвартай байрлагдсан эсэх / Cargo stable and correctly located to prevent unnecessary movement		
27	Ачааг хамгаалсан брезентээр зөв хучиж, даруулсан эсэх / Tarpaulins tied down correctly to cover and protect cargo		
28	Хуульд заасны дагуу ачаанд тохирсон шошго тэмдэг тавьсан эсэх / Vehicle correctly placarded according to cargo content regulations		
29	Анхны тусlamжийн хайрцаг / Emergency first aid kit		
30	Ослын зогсолтын гурвалжин тэмдэг / Emergency warning triangles flares		
31	Галын унтраагуур / Fire extinguisher		

Comments/Тайлбар:

Автомашины улсын дугаар: _____

Жолоочийн нэр: _____

Монгол улсын жолооны үнэмлэхийн дугаар: _____

Үзлэг хийсэн хүний нэр: _____

Гарын үсэг: _____

Үзлэг хийсэн он сар өдөр: _____